



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хутаг-Өндөр сумын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021 /92/-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

Г ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.АРИУНАА ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.09.25 № 103  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын 2019 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулаагүй, аудитад хамрагдаагүй, тайлант оны эхний үлдэгдэл баталгаажуулаагүй, сургуулийн захирал цалин, амралт давхардуулан авсан, худалдан авалтаас 19212.9 мянган төгрөгийн е-баримтын бүрдэл дутуу, зэрэг зөрчлүүд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

006020230

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>109,526,040.19</u></b>	<b><u>134,379,658.69</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	4,470,700.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	4,470,700.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	4,470,700.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	4,470,700.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	120,000.00	10,664,540.90
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	120,000.00	10,664,540.90
3351	Байгууллагаас авах авлага	00.00	10,390,930.90
3352	Хувь хүмүүсээс авах авлага	120,000.00	273,610.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	109,406,040.19	119,244,417.79
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	109,406,040.19	119,244,417.79
35410	Бичиг хэргийн материал	5,486,360.00	5,482,860.00
35420	Аж ахуйн материал	43,413,555.45	44,347,555.45
35430	Сэлбэг хэрэгсэл	2,047,407.40	5,864,780.00
35440	Түлш, шатах тослох материал	3,312,000.00	2,921,800.00
35450	Барилгын засварын материал	00.00	00.00
35460	Хүнсний материал	8,397,965.43	11,688,370.43
35470	Бусад хангамжийн материал	46,748,751.91	48,939,051.91
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,802,034,443.61</u></b>	<b><u>2,763,720,725.45</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,802,034,443.61	2,763,720,725.45
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,742,787,526.83	2,704,378,058.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,442,690,528.41	5,568,249,784.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,904,934,131.33	-3,126,923,493.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,000,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,000,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,404,416.00	214,754,225.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-200,652,645.79	-110,110,631.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,265,878.47	145,585,143.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	-151,812,625.34	-37,504,272.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,881,966.24	54,226,151.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,325,834.02	-26,301,821.43
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	45,269,974.19	22,402,972.65
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	59,246,916.78	59,342,666.68
39301	Програм хангамж	1,576,700.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-623,783.22	-106,333.32
39303	Бусад биет бус хөрөнгө	58,294,000.00	58,294,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,911,560,483.80</u></b>	<b><u>2,898,100,384.14</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,088,400.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,088,400.00	00.00

<b>413</b>	<b>Өглөг</b>	1,088,400.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	530,000.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	558,400.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	480,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	78,400.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,910,472,083.80</b>	<b>2,898,100,384.14</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,910,472,083.80	2,898,100,384.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	981,093,711.45	981,093,711.45
51101	Өмч: - төрийн	981,093,711.45	981,093,711.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-470,472,516.97	517,155,783.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-470,472,516.97	-470,472,516.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	987,628,300.34
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,399,850,889.32	1,399,850,889.32
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,911,560,483.80</b>	<b>2,898,100,384.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,558,448,574.01</b>	<b>2,849,785,284.07</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,666,874.01</b>	<b>1,254,476,884.07</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	90,666,874.01	1,254,476,884.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,666,874.01	1,254,476,884.07
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,666,874.01	1,254,476,884.07
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,467,781,700.00</b>	<b>1,595,308,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,136,491,000.00	1,298,393,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,136,491,000.00	1,292,593,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	5,800,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,424,100.00	521,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,724,100.00	21,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	323,866,600.00	296,393,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,866,600.00	296,393,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,794,635,905.58</b>	<b>1,832,587,608.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,794,635,905.58</b>	<b>1,832,587,608.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,751,497,240.18	1,676,017,472.27

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	831,410,228.60	915,149,407.13
210101	Үндсэн цалин	599,570,137.00	608,396,350.50
210102	Нэмэгдэл	106,312,691.60	239,835,283.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	125,527,400.00	66,917,773.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,710,293.00	113,947,132.00
210201	Тэтгэврийн даатгал	71,242,160.00	82,179,195.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,944,140.00	7,674,650.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,668,300.00	5,607,950.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,600,365.00	2,066,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,255,328.00	16,418,637.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	321,149,922.50	294,872,721.00
210301	Гэрэл, цахилгаан	9,465,289.00	6,965,687.00
210302	Түлш, халаалт	304,369,633.50	282,980,868.00
210303	Цэвэр, бохир ус	7,315,000.00	4,926,166.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,980,100.00	9,903,136.00
210401	Бичиг хэрэг	345,220.00	2,333,446.00
210402	Тээвэр, шатахуун	8,982,700.00	2,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	460,600.00	580,300.00
210404	Ном, хэвлэл	00.00	53,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,500.00	1,971,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,977,080.00	2,015,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	90,099,516.00	50,879,865.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	681,400.00	180,000.00
210502	Хоол, хүнс	84,749,951.00	48,688,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,668,165.00	2,011,260.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	369,300.00	1,536,500.00
210604	Урсгал засвар	369,300.00	1,536,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	337,100.00	837,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	337,100.00	837,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	439,300.00	1,528,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	343,300.00	1,528,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	391,001,480.08	287,363,411.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,649,440.00	1,329,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,265,944.00	1,785,684.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	370,086,096.08	284,248,427.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	43,138,665.40	156,570,136.37

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,532,849.00	23,249,477.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,797,849.00	21,649,477.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,735,000.00	1,600,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	37,840.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,840.00	00.00
213404	Хөрөнгийн	00.00	00.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,567,976.40	133,320,658.97
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,567,976.40	133,320,658.97
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-236,187,331.57</b>	<b>1,017,197,675.43</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	29,569,375.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	29,569,375.09
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-29,569,375.09
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-236,187,331.57</b>	<b>987,628,300.34</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,467,781,700.00</b>	<b>1,606,865,440.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>11,557,040.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	11,557,040.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	11,557,040.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	11,557,040.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,467,781,700.00</b>	<b>1,595,308,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,136,491,000.00	1,298,393,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,136,491,000.00	1,292,593,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	5,800,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,424,100.00	521,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,724,100.00	21,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	323,866,600.00	296,393,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,866,600.00	296,393,900.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,453,674,289.00</b>	<b>1,581,018,540.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,453,674,289.00</b>	<b>1,581,018,540.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,415,394,472.60</b>	<b>1,414,283,481.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	831,455,228.60	915,540,338.03
210101	Үндсэн цалин	562,729,700.00	583,668,250.00
210102	Нэмэгдэл	143,117,128.60	264,954,315.03
210104	Урамшуулал	125,608,400.00	66,917,773.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,710,293.00	113,947,132.00
210201	Тэтгэврийн даатгал	70,850,900.00	82,179,195.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,335,400.00	7,674,650.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,668,300.00	5,607,950.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,600,365.00	2,066,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,255,328.00	16,418,637.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	322,351,610.00	294,572,521.00
210301	Гэрэл, цахилгаан	9,915,289.00	6,965,687.00
210302	Түлш, халаалт	305,121,321.00	282,680,668.00
210303	Цэвэр, бохир ус	7,315,000.00	4,926,166.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,239,602.00	10,216,890.00
210401	Бичиг хэрэг	549,600.00	639,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,532,700.00	2,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	460,600.00	580,300.00
210404	Ном, хэвлэл	455,502.00	194,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,500.00	2,570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,026,700.00	3,282,690.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	90,295,600.00	60,824,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	681,400.00	481,400.00
210502	Хоол, хүнс	87,163,000.00	57,586,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,451,200.00	2,756,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,477,150.00	1,480,200.00
210604	Урсгал засвар	1,477,150.00	1,480,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	337,100.00	837,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	337,100.00	837,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,190,800.00	1,450,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,094,800.00	1,450,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,337,089.00	15,414,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,448,600.00	11,329,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,888,489.00	4,085,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,279,816.40</b>	<b>166,735,058.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	35,674,000.00	33,414,400.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,939,000.00	31,814,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,735,000.00	1,600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>37,840.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,840.00	00.00
213404	Хөрөнгийн	00.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,567,976.40</b>	<b>133,320,658.97</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,567,976.40	133,320,658.97
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,107,411.00</b>	<b>25,846,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,107,411.00</b>	<b>21,376,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,107,411.00</b>	<b>21,376,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>14,107,411.00</b>	<b>21,376,200.00</b>
220001	Барилга байгууламж	00.00	00.00
221001	Их засвар	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	13,090,011.00	19,860,000.00
223001	Бусад хөрөнгө	1,017,400.00	1,516,200.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-14,107,411.00</b>	<b>-21,376,200.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>4,470,700.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>4,470,700.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	922,799,711.45	898,564,736.05	-348,515,833.19	1,472,848,614.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>922,799,711.45</b>	<b>898,564,736.05</b>	<b>-348,515,833.19</b>	<b>1,472,848,614.31</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	501,286,153.27	00.00	501,286,153.27
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	58,294,000.00	00.00	00.00	58,294,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,230,647.79	114,230,647.79
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>981,093,711.45</b>	<b>1,399,850,889.32</b>	<b>-470,472,516.97</b>	<b>1,910,472,083.80</b>

D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>981,093,711.45</b>	<b>1,399,850,889.32</b>	<b>-470,472,516.97</b>	1,910,472,083.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>981,093,711.45</b>	<b>1,399,850,889.32</b>	<b>-470,472,516.97</b>	1,910,472,083.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	987,628,300.34	987,628,300.34
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>981,093,711.45</b>	<b>1,399,850,889.32</b>	<b>517,155,783.37</b>	2,898,100,384.14

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,635,293,300.00	1,447,176,881.03
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,635,293,300.00	1,447,176,881.03
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,589,375,400.00	1,413,762,481.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	976,464,000.00	915,540,338.03
210101	Үндсэн цалин	624,920,400.00	583,668,250.00
210102	Нэмэгдэл	243,806,000.00	264,954,315.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	107,737,600.00	66,917,773.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	126,181,600.00	113,947,132.00
210201	Тэтгэврийн даатгал	86,587,100.00	82,179,195.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,898,600.00	7,674,650.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,918,900.00	5,607,950.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,979,700.00	2,066,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,797,300.00	16,418,637.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	341,219,600.00	294,572,521.00
210301	Гэрэл, цахилгаан	13,166,800.00	6,965,687.00
210302	Түлш, халаалт	320,737,800.00	282,680,668.00
210303	Цэвэр, бохир ус	7,315,000.00	4,926,166.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,978,600.00	9,695,890.00
210401	Бичиг хэрэг	639,000.00	639,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,950,000.00	2,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	676,600.00	580,300.00
210404	Ном, хэвлэл	580,100.00	173,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	2,570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,932,900.00	2,782,690.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	95,235,400.00	60,824,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	481,400.00	481,400.00
210502	Хоол, хүнс	91,997,500.00	57,586,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,756,500.00	2,756,500.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,480,200.00	1,480,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	1,480,200.00	1,480,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	837,100.00	837,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	837,100.00	837,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,978,900.00	1,450,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,628,900.00	1,450,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15000000.00	15414300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	11,329,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,085,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45917900.00	33414400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	45,917,900.00	33,414,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,317,900.00	31,814,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,600,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>21,376,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	21,376,200.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	19,860,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	1,516,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	1,600,424,440.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	1,292,593,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	1,292,593,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	296,393,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	296,393,900.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	11,437,040.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	11,437,040.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	4,470,700.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	75.00	75.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ж.Ариунаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном нар хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Тус сургууль 2020 онд доорх зорилтуудыг тавьж хэрэгжүүлж ажиллаа.

- Удирдлага, зохион байгуулалтын менежментийг эрчимжүүлэх, бодлогын баримт бичгүүдийг цэгцэлж, журамлах
- Нэгж, ээлжит хичээлийн бэлтгэл, үр нөлөөг дээшлүүлэх, массын сургалтын чанарыг ахиулах
- Суралцагчдаас хөндлөнгийн үнэлгээг авах, суралцагчдын бодит чадварыг нэмэгдүүлэх, олимпиад, ЭЕШ-ын бэлтгэлийг хангах
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд нэг бүрийн авьяас чадварыг хөгжүүлэх
- 240 хүүхдийн хичээлийн байрны өргөтгөлийг ашиглалтад оруулах, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах
- Тус сургуулийн үйл ажиллагаа 2020 онд танхимаар болон онлайнаар явагдаж өнгөрлөө.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дотоод аудитын газар 2020 онд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж нийт 10443.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 5110.3 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, 5333.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, цаашид анхаарч ажиллах 5 зөвлөмж өгсөн байна.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн үр дүнгийн тайлангийн 1862156.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 37243.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1862156.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 37243.1 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 986539.9 мянган төгрөгөөр буюу 51.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4470.7	4470.7
Авлага	120.0	10664.5	10544.5
Урьдчилгаа			
Бараа материал	109406.0	119244.4	9838.4
Үндсэн хөрөнгө	1802034.4	2763720.7	961686.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1911560.5</b>	<b>2898100.4</b>	<b>986539.9</b>
Өр төлбөр	1088.4		-1088.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1910472.1	2898100.4	987628.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1911560.5</b>	<b>2898100.4</b>	<b>986539.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4470.7 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд ахмадын сан байгуулж, сангийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 10664.5 мянган төгрөг болж 10544.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 119244.4 мянган төгрөг болж 9838.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авалт хийсэн ч хорио цээртэй холбоотой үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбоотой материалын үлдэгдэл үлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2763720.7 мянган төгрөг болж 961686.3 мянган төгрөгөөр өссөн нь хичээлийн өргөтгөлийн 1125559.3 мянган төгрөгийн барилгыг орлогод авсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 21376.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 1254127.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 143638.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1088.4 мянган төгрөгийг барагдуулж тайлант онд өглөг үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2898100.4 мянган төгрөг болж 987628.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1291336.7 мянган төгрөгөөр буюу 82.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого 1163810.0 мянган төгрөгийн орлого байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1668077.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1668077.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 32784.4 мянган төгрөгөөр бууруулж 1635293.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1635293.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1292593.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 342699.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1292593.5, орон нутгийн төсвөөс 296393.9 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 1588987.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1469074.1 мянган төгрөгийг зарцуулж 133320.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1469074.1 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь цалингийн зардал 60923.7, байр ашиглалт 46647.1, хангамж, бараа материал 19761.7 норматив 34410.6 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 500.0 мянган төгрөг санхүүжилтийг орлогоор бүртгэсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 38967.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, мянган төгрөгийн алдааг залруулж, 1526.2 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 862.5 мянган төгрөгийн

зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 36579.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 2388.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1526.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 862.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

1. Сургуулийн захирлын 2020 оны А/49 тоот тушаалаар шагналын дагалдах мөнгө олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дахь "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

2. Сургуулийн захирал Д.Ган-Эрдэнэ амралтын хугацаанд 10 хонгийн цалин 689.2 мянган төгрөгийн цалин давхардуулан авсан.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 862.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 36579.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

4Илрүүлэлт: Төсөвт батлагдаагүй байхад цалингийн зардлаас 5800.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйл 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухай үлдэгдлийг тухай шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.3-д "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.1. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

1.2. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж, төсөвт төлөвлөн батлуулж байх.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн

## 2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 10664.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж өр авлага үүсгэхгүй ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн

## 3. Зардлын данстай холбоотой асуудал:

3.1. Илрүүлэлт: Түүчээ Намнан ХХК-иас хийсэн худалдан авалтаас 19212.9 мянган төгрөгийн НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг зөрчсөн.

3.2. Эрсдэл: Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгоно.

3.3. Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх; анхан шатны баримтын бүрдлийг хангуулан тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн

3.1. Илрүүлэлт: Бараа материалын дансанд 11566.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС-16-д "Үндсэн хөрөнгө гэж дараах шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах" хөрөнгийг хэлнэ гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл: Заавар, журам зөрчигдөж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сурах.

3.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг данс хооронд шилжүүлэх хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлж үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн.

3.1. Илрүүлэлт: Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 151 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж санхүүгийн тайлан, төсөв, гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг хугацаанд нь цахим мэдээллийн санд байршуулж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	.... 20.. оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
20..			САГ-20.././СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	.....		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1					
2					
3					
	<b>ДҮН</b>				